

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

2025.06.09

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		
Салбарын хууль тогтоомж, норм, стандартын хэрэгжилтэд хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих 2.4.6. зорилтын хүрээнд:								
4.3.1	Зорилт 1. Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	Улсын төсөв	Хууль сахин мөрдөлт (хувь)	65.5%	56%		Салбарын хяналтын газар	
1.	Хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын салбарын чиглэлээр их, дунд эрсдэлийн ангилалд хамаарах 1416 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулах, шалгалтын дүнд дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	-Хяналт шалгалт хийсэн объект (тоо), (хувь)	1090 73.3%	566 37,5%	1132 75%	Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор баталсан Хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны А/78 дугаар тушаалаар баталсан Хяналт шалгалтын объектын жагсаалт батлах тухай тушаалыг тус тус үндэслэн 2025 онд хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын чиглэлээр улсын хэмжээнд хийгдэх төлөвлөгөөт хяналт шалгалтын 2 удирдамжийг боловсруулан, ХХҮЕГ болон НДЕГ-т ГБХНХЯ-ны 2025.01.10-ны өдрийн 03/77 дугаартай албан бичгээр хүргүүлэв. Нийт 1416 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээс 2025.06.09-ний өдрийн байдлаар 586 буюу 41.2 хувьтай хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. зөрчил арилгалт 36,6% хувьтай, хууль сахин мөрдөлтийн түвшин 59 хувь, эрсдэл үүсэх магадлал 32 хувьтай байна. Удирдамжид заасан хугацаанд хяналт шалгалтуудыг эхлүүлж, улсын байцаагчдыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна.	100
			-Арилгасан зөрчил (хувь)	61.6%	31,5%	63%		
			- Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувь)	64.8%	32,5%	65%		
			-Эрсдэл үүсэх магадлал (хувь)	35.2%	15%	35%		

2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Төрийн бус байгууллагатай хамтран Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн улсын үзлэг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Үзлэгт хамрагдсан 25 - аас дээш ажилтантай ААНБ (тоо)	0	300	700	Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/102 дугаар тушаалаар Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтийн байдалд улсын үзлэг зохион байгуулах удирдамжийг баталсан. Удирдамжийн хүрээнд 25 аас дээш ажилтантай 501 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийгдсэнээс 33 аж ахуйн нэгж байгууллагад 496,285,4 (дөрвөн зуун ерэн зургаан сая хоёр зуун наян таван мянга дөрвөн зуу) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нөхөн төлүүлэх хөдөлмөрийн хяналтын улсын /ахлах/ байцаагчдын нөхөн төлбөрийн акт тавигдсан байна. 2025.06.09-ны өдрийн байдлаар 214,976,0 (хоёр зуун арван дөрвөн сая есөн зуун далан зургаан мянга)төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж, барагдуулалтын хувь 43 хувьтай байна.	100
			Хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	0	40%	80%		
3.	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд ХХҮЕГ, НДЕГ-ын улсын (ахлах) байцаагч нартай хамтран (Баруун, Төв, Зүүн, Говийн бүсэд) хяналт шалгалт хийх, орон нутгийн улсын байцаагчдын ажлыг газар дээр нь үнэлж, дадлагажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх	Улсын төсөв	Байцаагчдын тоо	0	-	116	Баруун, Төв, Зүүн, Говийн бүсэд хяналт шалгалт хийх, орон нутгийн улсын байцаагчдын ажлыг газар дээр нь үнэлж, дадлагажуулах, нөхцөл байдлын шинжилгээ хийх тухай Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын удирдамжийг хавсралтын хамт боловсруулан газрын даргаар хянуулан ТНБД-д танилцуулахаар бэлтгэсэн. Томилолтын зардал шийдэгдээгүй байна. Улсын байцаагчдыг чадавхижуулах сургалтын материалуудыг бэлтгэсэн. 2-р улирлаас эхэлсэн арга хэмжээ	90
4.	Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд Гадаадын иргэн харьяатын газартай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Хамрагдсан объектын тоо	0	3	200	ГБХНХЯ-ны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан Монгол Улсад ажиллаж буй гадаад улсын иргэдийн хүн худалдаалах болон албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдэх хамтарсан хяналт шалгалтыг зохион байгуулах талуудын уулзалтыг 2025.05.15—	100
			Зөрчил барагдуулалт (хувь)	0	30%	80%		

							ны өдөр ГБХНХЯ дээр зохион байгуулсан. Уулзалтад ГБХНХЯ ГХУСАЗ-ийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар Гадаадын , иргэн харьяатын газрын төлөөллүүд оролцож, ГХУСАЗЗАА-ны даргын 2025.05.16-хэсгийг байгуулсан	
							Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 08-07/16 дугаартай Гадаадаас ажилтан авч ажиллуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудын гадаад ажилтны хөдөлмөр эрхлэлтэд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай хамтарсан хяналт шалгалтын удирдамжийг батлуулж , аймаг, дүүргийн хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад хүргүүллээ. Хяналт шалгалтад 386 аж ахуйн нэгжийн 526 гадаад иргэн хамрагдаж, 3 аж ахуйн нэгжид 532620.0 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн акт тавьж 29700.0 мянган төгрөгийн барагдуулж зөрчил барагдуулалт 6 хувьтай байна. Хяналт шалгалт үргэлжилж байгаа. Дүн мэдээг 2025 оны 3 дугаар улиралд нэгтгэж танилцуулна.	
5.	Онцгой байдлын ерөнхий газартай хамтран аймаг, нийслэл, дүүргийн онцгой байдлын байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтэд улсын үзлэг зохион байгуулж, дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Үзлэг хийсэн объект (хувь)	0	152 100%	152	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга болон Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр хамтран баталсан удирдамжийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрын харьяа 152 газар, хэлтэс, анги, салбаруудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн улсын үзлэгийг 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрөөс 02 дугаар сарын 27-ны өдрүүдэд аймаг, нийслэл, дүүрэг дэх салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх байгууллагын хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын (ахлах) байцаагчид хийж гүйцэтгэв. Үзлэгийн дүнгээр Онцгой байдлын ерөнхий газар болон түүний харьяа нэгжүүдэд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн	100

							тухай хуулийн хэрэгжилт нийт салбарын хэмжээнд дунджаар 54 хувьтай үнэлэгдэв. Улсын үзлэгийн дүнг ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга болон ОБЕГ-ын удирдлагуудад танилцуулах хурлыг 2025.05.19-ны өдөр зохион байгуулж, үзлэгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, төрийн тусгай албан хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор ОБЕГ-т Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 07/00-00/001-01 тоот албан даалгаврыг хүргүүлсэн.	
6.	Уул уурхай, олборлолт, хуурай замаар хийгдэх ачаа тээврийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	-Арилгасан зөрчил (хувь) -Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувь) -Эрсдэл үүсэх магадлал (хувь)	68.2% 58.9% 41.1%	34,5% 30% -	69% 60% 40%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан 08-07/03 дугаартай удирдамжаар хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 83 объектыг хамруулж 1181 зөрчил илрүүлж, 40,550,000 төгрөгийн торгууль, 930,605,700 төгрөгийн нөхөн төлбөр тавьж, зөрчил арилгалт 36 хувьтай, хууль сахин мөрдөлтийн түвшин 52 хувь, эрсдэл үүсэх магадлал 48 хувьтай шалгалт үргэлжлэн хийгдэж байна.	90
7.	Ус хангамж, сувагжилт, хог хаягдлыг хуримтлуулах, түгээх, зайлуулах, боловсруулах, ариутгах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	-Арилгасан зөрчил (хувь) -Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувь) -Эрсдэл үүсэх магадлал (хувь)	0 0 0	32,5% 32,5% -	65% 65% 35%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан 08-07/04 дугаартай удирдамжаар хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 181 объектыг хамруулж 1750 зөрчил илрүүлж, 31,000,000 төгрөгийн торгууль, 282,216,500 төгрөгийн нөхөн төлбөр тавьж, зөрчил арилгалт 35 хувьтай, хууль сахин мөрдөлтийн түвшин 62 хувь, эрсдэл үүсэх магадлал 38 хувьтай шалгалт үргэлжлэн хийгдэж байна.	90
8.	Барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн	Улсын төсөв	-Арилгасан зөрчил (хувь)	66.2%	34%	68%	Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр баталсан	90

	чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагуудад урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах, танилцуулгад дүн шинжилгээ хийх		-Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувь)	57.9%	30%	60%	08-07/05 дугаартай удирдамжаар хийгдсэн урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 249 объектыг хамруулж 2157 зөрчил илрүүлж, 30,350,000 төгрөгийн торгууль, 18,547,700 төгрөгийн нөхөн төлбөр тавьж, зөрчил арилгалт 40 хувьтай, хууль сахин мөрдөлтийн түвшин 53 хувь, эрсдэл үүсэх магадлал 47 хувьтай шалгалт үргэлжлэн хийгдэж байна.	
			-Эрсдэл үүсэх магадлал (хувь)	42.1%	-	40%		
9.	Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	Улсын төсөв	-Хяналт шалгалт хийсэн объектын тоо	0	15	30	Салбарын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 08-07/06 дугаартай "Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын гүйцэтгэлд 20 аймаг, 8 дүүргийг хамруулан шалгалаа. Булган аймагт нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчгүй, Багахангай дүүрэгт НДЕГ-ын ХШГ-ын төлөвлөгөөт хяналт шалгалттай хугацааны хувьд давхардсан тул хяналт шалгалт хийгдээгүй болно. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд улсын /ахлах/ байцаагчийн нийт 89 заалт бүхий 714,880.7 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн 26 акт, улсын /ахлах/ байцаагчийн 59 заалт бүхий 18 албан шаардлага тус тус хүргүүлсэн. Үүнд: 616 иргэнд 566.6 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг илүү олгосон, мөн 267 иргэнд 144.3 сая төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг дутуу тооцож олгосон зөрчлийг илрүүлэн улсын /ахлах/ байцаагчийн акт тогтоосон. Ажилгүйдлийн даатгалын сангийн 2022-2024 оны бүрдүүлэлт, зарцуулалтад хийсэн шалгалтаар илэрсэн нийт 711.1 сая төгрөгийн зөрчлөөс барагдуулалт нь хагас жилийн байдлаар 60.6 сая төгрөг буюу 8,5 хувийн гүйцэтгэлтэй байна. Хяналт шалгалт үргэлжлэн хийгдэж байна.	70
			-Арилгасан зөрчил (хувь)	0	32,5%	65%		

10.	Иргэний өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Улсын төсөв	-Хуулийн хугацаанд судалж шийдвэрлэсэн хүсэлт, өргөдөл, гомдол, нийт хүсэлт өргөдөл, гомдолд эзлэх хувь	111	42,5%	85%	2025 оны эхний хагас жилийн байдлаар 54 өргөдөл, гомдол ирсэн. 45 өргөдөл гомдол буюу 83,3 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 9 өргөдөл гомдол буюу 16,7 хувь нь хугацаандаа шийдвэрлэх шатанд явж байна. Өргөдөл гомдлын дагуу хийгдсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийн 90 хувийг арилгасан.	90
			-арилгасан зөрчил (хувь)	90%	47,5%	95%		
11.	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийн дагуу хийгдэх ажил	Улсын төсөв	-Хуулийн хугацаанд судалж шийдвэрлэсэн хариутай албан бичиг, нийт хариутай албан бичигт эзлэх хувь	90%	47,5%	95%	2025 оны эхний хагас жилийн байдлаар 104 албан бичиг ирсэн. 98 албан бичиг буюу 94.2 хувийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн. 6 албан бичиг буюу 5.7 хувь нь хугацаандаа шийдвэрлэх шатанд явж байна.	100
12.	Удирдах дээд байгууллага, албан тушаалтны үүрэг даалгаврын дагуу хийгдэх ажил	Улсын төсөв	-Хуулийн хугацаанд судалж шийдвэрлэсэн тоо	3	2	4	1.Төрийн нарийн бичгийн даргын өгсөн даалгаврын дагуу Өмнөговь аймгийн Гурван тэс суманд байрлах Сино хайдро корпорэйшн монголиа ГХОХХК-д төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 32 заалт бүхий 07/00-02/004-02 дугаартай албан шаардлага өгч, ЗТХ-иар 10 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож, хөгжлийн бэрхшээлтэй хүн ажиллуулбал зохих орон тоо тутамд ногдох төлбөрийг сар бүр төлөөгүй зөрчилд 69,960,000 (жаран есөн сая есөн зуун жаран мянга) төгрөгийг Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд	90

			-Арилгасан зөрчил (хувь)				санд нөхөн төлүүлэх, 2024 онд ээлжийн хуваарийн дагуу шөнийн цагаар болон илүү цагаар ажилласан ... ажилтны нэмэгдэл хөлс 907,542,913 (есөн зуун долоон сая таван зуун дөчин хоёр мянга есөн зуун арван гурав) төгрөгийг нөхөн олгуулахаар Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагчийн акт тогтоож ажиллалаа. 2.Төрийн нарийн бичгийн даргын өгсөн даалгаврын дагуу Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр аутсорсинг үйлчилгээ үзүүлдэг Чинзо Сейфти Инженеринг ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.Чинзоригтой хөдөлмөрийн аюулгүй байдлын апплейкейшны хөгжүүлэлтийн асуудлаар санал солилцож, зөвлөгөө өгсөн. 3.Төрийн нарийн бичгийн даргын ажлын хэсэг байгуулах тухай А/64 дүгээр тушаалын дагуу 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 03 дугаар сарын 20-ны өдөр хүртэлх хугацаанд "Монголын СОС-ын хүүхдийн хотхоны нийгэмлэг" төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлт гаргах зорилгоор хяналт шалгалт хийж, танилцуулгыг Хяналт-Шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт хүргүүлсэн байна. 4. Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрмийг шинэчлэх ажлын хэсэгт ажиллаж, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025.01.10-ны өдрийн А/06, А04 дугаартай хамтарсан тушаалаар Хүдрийн далд уурхайн аюулгүй байдлын дүрэм батлагдсан. 5. Улсын онцгой комиссын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 60 дугаартай Хяналт шалгалт зохион байгуулах тухай албан бичгийг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүн хадгалах, худалдаалах, түгээх, цэнэглэх, тээвэрлэх чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж,	
--	--	--	-----------------------------	--	--	--	--	--

						байгууллагуудад төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 08-07/13 дугаартай удирдамжийн хүрээнд 36 ААНБ-д хяналт шалгалт хийгдэж, шалгалтын танилцуулга нэгтгэгдэж байна. 6. Хяналт шалгалтын уялдаа холбоог хангах зорилгын хүрээнд 2025 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу Аж үйлдвэр, эрдэс баялгийн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамдын Салбарын улсын ерөнхий байцаагчдын хамтран баталсан 2025.05.14-ний өдрийн 06-00/22 дугаартай удирдамжийн дагуу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалтыг 2025 оны 05 дугаар сарын 22-26-ны өдрүүдэд хийсэн. Хяналт шалгалтад Эрдэнэс тавантолгой ХК болон тус компанитай хөрс хуулалт, нүүрс олборлолтын гэрээ байгуулан ажиллаж буй Кей Эй майнинг ХХК, Нормаунт ХХК, тэсэлгээний ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж буй Спейшл майнинг сервис ХХК-иуд хамрагдсан. Хяналт шалгалтын дүн, танилцуулга нэгтгэгдэж байна. Хяналт шалгалтын хүрээнд ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад салбарын хууль тогтоомжийг сурталчлах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл, гарч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Ш.Хонгорзул “Хөдөлмөрийн хууль тогтоомжийн хэрэгжилт”, “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх”, мөн яамны Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналын улсын ахлах байцаагч Ч.Бүжинлхам “Хөдөлмөрийн эрүүл ахуй, мэргэжлээс шалтгаалах өвчин, урьдчилан сэргийлэх арга
--	--	--	--	--	--	--

							хэмжээ” сэдвээр сургалт зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Удирдах дээд байгууллага, албан тушаалтны үүрэг даалгаврын дагуу хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн зөрчил арилгалт 40 хувьтай байна.	
13.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын бүртгэлийн цахим системд 2024 онд бүртгэгдсэн үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын мэдээлэлд дүн шинжилгээ хийх (салбараар)	Улсын төсөв	-Хянан баталгаажуулсан актын тоо	711	251	711	2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйлдвэрлэлийн осол хурц хордлогын 711 тохиолдолд нийт 809 хүн өртөж, үүнээс 87 хүн нас барсан, 722 хүн бэртэж, гэмтсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 10,7 хувь байна. - Уул уурхай, олборлолтын салбарт 118 ослын тохиолдолд 127 хүн өртөж, үүнээс 13 хүн нас барж, 114 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 16,6 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт гарсан байна. Ослын 1 тохиолдолд 7 хүн өртсөн бүлэг осол 1, 2 хүн өртсөн бүлэг осол 3, нийт 4 бүлэг осолд 13 хүн өртсөн байна. - Барилгын салбарт 62 ослын тохиолдолд 66 хүн өртөж, үүнээс 16 хүн нас барж, 50 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 8,7 хувийг хамаарч байна. - Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 99 ослын тохиолдолд 108 хүн өртөж, үүнээс 7 хүн нас барж, 101 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 14,0 хувь нь тус салбарт гарсан байна. - Тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт 70 ослын тохиолдолд 77 хүн өртөж, үүнээс 13 хүн нас барж, 64 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 9,8 хувийг хамаарч байна.	90
			-Дүн шинжилгээ хийсэн тоо	1	1	2	2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар нийт 236 тохиолдолд 251 хүн үйлдвэрлэлийн осолд өртөж, үүнээс 22 хүн нас барсан, 229 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт осолд нас баралтын эзлэх хувь 8,7 хувь байна. - Уул уурхай, олборлолтын салбарт 36 ослын	

						тохиолдолд 36 хүн өртөж, үүнээс 5 хүн нас барж, 31 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 15,2 хувь нь уул уурхай, олборлолтын салбарт гарсан байна. - Барилгын салбарт 13 ослын тохиолдолд 13 хүн өртөж, үүнээс 3 хүн нас барж, 10 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 5,5 хувийг хамаарч байна. - Боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 32 ослын тохиолдолд 32 хүн өртөж, үүнээс 1 хүн нас барж, 31 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 13,5 хувь нь тус салбарт гарсан байна. - Тээвэр болон агуулахын үйл ажиллагааны салбарт 29 ослын тохиолдолд 32 хүн өртөж, үүнээс 2 хүн нас барж, 30 хүн гэмтэж, бэртсэн байна. Нийт ослын тохиолдлын 13,5 хувийг хамаарч байна. - Бусад салбарт 123 тохиолдол гарсан. Ослын 1 тохиолдолд 2 хүн өртсөн бүлэг осол 6, 3 хүн өртсөн бүлэг осол 1, нийт 7 бүлэг осолд 15 хүн өртсөн байна. Нийт тохиолдлын 7 буюу 3 хувь нь бүлэг осол байна. Унаж, бүдрэх халтирсны улмаас үйлдвэрлэлийн осолд өртсөн нь нийт шалтгааны 33.1 хувийг, эд зүйлд хавчуулагдах шалтгаан 14,3 хувийг, унаж байгаа эд зүйлд цохигдох шалтгаан 8.7 хувийг тус тус эзэлж байна. Осол гарахад нөлөөлсөн хүчин зүйлийн 47,4 хувь нь хүний, 32,6 хувь нь ажлын байр, орчны, 9,5 хувь нь техник технологийн, 10,8 хувь нь удирдлагын тогтолцооны хүчин зүйлээс хамаарсан байна. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого бүртгэгдсэн аймаг, дүүргээс Өмнөговь аймаг 34 буюу 14,5 хувь, Баянгол, Хан-Уул дүүрэг тус бүр 25 буюу 10,6 хувийг хамаарч байна. 2025 оны 06 дугаар сарын 09-ны өдрийн байдлаар 10,000 хүнд ногдох хүндрэлийн коэффициент 0,15, ослын коэффициент 1,82, 100,000 хүнд оногдох нас баралт 1,5 байна.	
--	--	--	--	--	--	--	--

ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

4.3.2	Зорилт 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, орчны аюулгүй байдалд хяналт тавих эрх зүйн актыг боловсронгуй болгох	Улсын төсөв	Эрх зүйн акт /тоо/	1	3	I-IV улирал	Салбарын хяналтын газар	
1.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийг шинэчлэн боловсруулах	ҮОМШ ӨДСан	Шинэчлэн боловсруулсан дүрмийн төсөл /тоо/	1		1	Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийг шинэчлэх ажлын хэсгийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/170 дугаартай тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг дүрмийн төслийг боловсруулж, 2023-2024 онд 4 удаагийн хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох талуудаас санал авч ажилласан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалттай холбоотойгоор үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрмийн боловсруулалтад өөрчлөлт хүлээгдэж байна.	90
2.	Хөдөлмөрийн хяналтын бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах	Улсын төсөв	Баримт бичиг	1	-	1	Салбарын хяналтын чиг үүрэг мэргэжлийн хяналтын байгууллагад хамаарч байх үед буюу 2010 онд Монгол Улсын Шадар сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 37/89 тоот хамтарсан тушаалаар “Монгол улсын хөдөлмөрийн хяналтын шинэчлэлийн үндсэн чиглэл” бодлогын баримт бичиг батлагдаж байсан байна. 2023 онд хяналтын чиг үүрэг эргэн Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжин ирсэнтэй холбоотойгоор 2024 онд Хөдөлмөрийн хяналтын бодлогын баримт бичгийн төслийг Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Хөдөлмөрийн хяналтын ерөнхий зарчмуудын тухай удирдамжид нийцүүлэн боловсруулж, ОУХБ-ын Хөдөлмөрийн хяналтын (LABGOV)	90

							хэлтэст хүргүүлэн зөвлөгөө авсан. Уг байгууллагаас ирүүлсэн зөвлөмжид "Монгол Улсад 2023 онд хэрэгжүүлсэн бүтцийн өөрчлөлтийн үр дүнд "хөдөлмөрийн харилцаа," "хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд," "нийгмийн хамгаалал"-тай холбоотой хөдөлмөрийн хяналтын чиг үүргийг буцаан Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд харьяалуулж, "Салбарын хяналтын газар" байгуулсныг сайшаан, үндэсний хөдөлмөрийн хяналтын тууштай бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны удирдан чиглүүлж, уялдуулан зохицуулах үүрэг маш чухал болохыг, мөн Монгол Улсын хөдөлмөрийн хяналтын бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд явцын хяналт хийх, үнэлгээ хийх бүхий л шатанд нийгмийн түншүүдтэй зөвлөлдөх, тэдний оролцоог хангахын ач холбогдлыг онцлон дурдсан байна. Бодлогын төслийг боловсруулсан.	
3.	Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг мэдээллээр хангах	Улсын төсөв	Объектын тоо	19578	0	19600	2024 оны сүүлээр хяналт шалгалтын 19578 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг мэдээллээр хангаж ажилласан. Объектын эрсдэлийн үнэлгээг үндэслэн хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2025 онд төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтыг 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн ГБХНХ-ын сайдын А/78 дугаар тушаалаар баталсан. 2026 онд хийгдэх объектод эрсдэлийн үнэлгээг 2025 оны 11 дүгээр сард хийж 2025 оны 12 дугаар сард хяналт шалгалт хийх объектоо зарлана.	Х/б
4.	Хяналт шалгалтын үйл ажиллагаанд хэрэглэгдэх хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах /Төрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 9.2.1, 5.19/	Улсын төсөв	Хяналтын хуудасны тоо	0	1	1	Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дүгээр зүйлийн 145.4-т нэмэлт өөрчлөлт орсон тул 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудаст ГБХНХСайдын 2025.02.18-ны өдрийн А/46 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулан	100

							батлуулсан.	
5.	Шилэн хяналтын цахим системийн мэдээллийн сан бүрдүүлэх, цахим системийн ашиглалт, үр дүнд хагас бүтэн жилээр дүн шинжилгээ хийж, тайлагнах;	Улсын төсөв	Дүн шинжилгээний тоо	2	1	2	СХГ-аас 2025 онд хийгдэх хяналт шалгалтыг төлөвлөхдөө их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн боловсруулах үйлдвэрүүд болон цахилгаан эрчим хүчний салбарыг сонгон нийт 1416 объектыг хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөн ГБХНХ-ын сайдын А/78 дугаар тушаалаар баталж , www.shilenkhyanalt.gov.mn цахим бүртгэлийн системд 1416 объектыг хяналт шалгалт хийхээр оруулсан. Улсын байцаагчдын хяналт шалгалт эхлүүлэхээр хүсэлт гаргасан оруулсан хяналт шалгалтын 500 объектуудыг хянан нягталж, бусад чиглэлийн улсын байцаагч нартай хамтарсан хяналтуудыг үүсгүүлэн, баталгаажуулж, хяналт шалгалтыг эхлүүлсэн төлөвт оруулж, цахим бүртгэлийн системийн явцыг газрын удирдлагад тайлагнасан.	70
6.	Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга), Ажиллах хүч шилжилт хөдөлгөөний тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд, тэдгээрийг дагалдаж гарах Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд санал өгөх	Улсын төсөв	Саналын тоо	8	6	12	1. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ны өдөр зохион байгуулсан -2025.05.07 Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгатай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд орох нэмэлт өөрчлөлтийн төсөл 25 санал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн харьяалалд 4 санал өгсөн 2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж Зөрчлийн тухай хуульд орох нэмэлт өөрчлөлтийн төсөлд 7 санал, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн харьяалалд 2 санал өгсөн.	100
7.	Хяналт шалгалтад хамрагдсан	Улсын төсөв	Дүн шинжилгээний тоо	0		1	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/46 дугаар Хяналтын хуудаст	90

	байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх						нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тушаалаар 07.1.1 кодтой Хөдөлмөрийн харилцааг шалгах хяналтын хуудаст Хөдөлмөрийн тухай хуулийн 145 дугаар зүйлийн 145.4 дэх хэсгийн хэрэгжилтийг шалгах асуумжийг нэмж батлуулсан. 2025 оны 2 дугаар улиралд хийгдэхээр төлөвлөсөн ажил буюу Хяналтын хуудасны нэмэлт өөрчлөлтийн талаар хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад цахим зөвлөгөө өгөх ажил бүрэн хийгдээд байна. Хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх ажил төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх шалгалтын танилцуулгад үндэслэн 2025 оны 4 дүгээр улиралд хийгдэнэ.	
8.	Салбарын хяналтын үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журмыг хуульд нийцүүлэн боловсруулах	Улсын төсөв	Журам	0		1	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналт шалгалтын зохицуулах журам"-ын төслийг боловсруулж, төсөлд яамны Салбарын хяналтын газар, ХХҮЕГ, НДЕГ болон тэдгээрийн харьяа аймаг, нийслэл, дүүргийн газар /хэлтэс/-ийн албан тушаалтнаас бичгээр санал авч нэгтгэв. Мөн яамны газар /хэлтэс/-ийн удирдах албан тушаалтнуудад танилцуулж, саналыг авч боловсруулалт хийж, эрх зүйн актыг хүчин төгөлдөр болгох нөхцөлийг хангаж, 2025 оны эцэст баталгаажуулж мөрдөнө.	90
9.	Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтныг хууль зүйн мэдээллээр хангаж, зөрчлийн арга хэмжээнд дүн шинжилгээ хийх	Улсын төсөв	Дүн шинжилгээ тоо	2	1	2	1. "Зөрчлийн тухай хуульд орсон торгох шийтгэлийн хэмжээг хөнгөрүүлэх, нэмэгдүүлэх үндэслэл, эрхийг хязгаарлах, эрх хасах нэмэгдэл шийтгэл оногдуулж байгаа байдал, түүнтэй нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөж буй аргачлал, журмын хэрэгжилтийн байдлыг судлах" судалгааг гаргаж, 2025 оны 02 сарын 26-ны өдрийн 08/663 дугаартай албан бичгээр Нийслэлийн прокурорын газарт хүргүүллээ. Улсын/ ахлах/ байцаагчдаас 2025 оны эхний хагас жилд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан талаар дүн шинжилгээ хийж Салбарын хяналтын газрын даргад тайлагнасан. 2.Мөн зөрчил шалган шийдвэрлэх	90

							ажиллагаанд хяналт тавих прокурорын хяналтын харьяаллыг шинэчлэн боловсруулах төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08/812 дугаартай албан бичгээр Улсын ерөнхий Прокурорын газарт хүргүүлэв.	
ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ								
4.1 Хяналтын байгууллагын үйл ажиллагааны үр дүнтэй, хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилтын хүрээнд:								
1.	Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шинэчилсэн цахим бүртгэлийн системийн ашиглалтын талаар улсын (ахлах) байцаагчдад сургалт зохион байгуулах	Улсын төсөв	Сургалтын тоо	0	-	1	ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, “Бодь электроникс” ХХК-ийн гүйцэтгэх захирал нарын хамтран баталсан “Гэрээнд өөрчлөлт оруулах тухай” №202111014+1 дугаартай гэрээний ажил хүлээлцэх хугацаанд өөрчлөлт оруулж 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр шинэчлэн байгуулсан. Гэрээний хугацаа 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дуусна. Бодь электроникс” ХХК Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын шинэчилсэн цахим бүртгэлийн системийг шинэчлэн хөгжүүлж хүлээлгэж өгсөний дараа улсын (ахлах) байцаагч нарт дадлагажуулах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажил ханган ажиллаж байна.	50
2.	Төрийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд Зөрчлийн хэрэг бүртгэлийн үйл ажиллагаа явуулах эрх бүхий албан тушаалтны сургалтыг Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газартай хамтран зохион байгуулах	Улсын төсөв	Хамрагдсан улсын (ахлах) байцаагчийн тоо	0	58	116	Улсын Ерөнхий прокурорын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр “Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-г хэрэглээнд нэвтрүүлэх зорилгоор Салбарын хяналтын газар, Гэр бүлийн бодлогын газрын болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар тэдгээрийн харьяа газар, хэлтсийн зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах эрх бүхий 116 албан тушаалтан /хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хүүхдийн эрхийн байцаагч/-ыг хамруулан сургалтыг зохион байгуулсан.	100

							Сургалтыг батлагдсан хөтөлбөрийн дагуу УЕПГ-ын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Б.Соёлсайхан Зөрчлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар, хяналтын прокурор М.Энхтунгалаг Зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн модификациудын талаар, "Ай Ти Зон" ХХК-ийн програмист А.Буяндэлгэр программ хангамжтай холбоотой асуудлаар сургалт явууллаа. Монголын хараагүйчүүдийн холбооны харьяа "Cofe More" салбараас суралцагчид завсарлагаанаар цай, кофе, сендвич, кэк, цэвэр ус зэрэг 700,000 /долоон зуун мянга/ төгрөгийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн бөгөөд тайланг Улсын Ерөнхий прокурорын газарт хүргүүлсэн.	
3.	Төрийн захиргааны төв болон агентлаг, орон нутгийн улсын (ахлах) байцаагчдыг чадавхжуулах сургалтыг Хяналт, үнэлгээний Үндэсний хороотой хамтран зохион байгуулах	Улсын төсөв	Хамрагдсан улсын (ахлах) байцаагчийн тоо	0	59	117	Хяналт, үнэлгээний Үндэсний хороотой хамтран аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар /хэлтэс/, Нийгмийн даатгалын газрын хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагчдад Төрийн хяналт шалгалтын тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн даатгалын тухай, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлаар улсын /ахлах/ байцаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, чадавхжуулах сургалтыг цахимаар 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 117 улсын байцаагчдыг хамруулан зохион байгуулсан. Хяналт, үнэлгээний Үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Н.Лхагвадорж болон бусад албаны хүмүүс оролцлоо. Хэлэлцүүлгээр Салбарын хяналтын газрын хөдөлмөрийн хяналтын улсын ахлах байцаагч Ш.Хонгорзул, хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагч	100

							Ч.Бүжинлхам, Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч П.Хорлоо, ЗШША хариуцсан шинжээч Я.Дамдинрагчаа нар хяналтын чиглэл тус бүрээр хичээл зааж, улсын /ахлах/ байцаагч нараас гаргасан санал хүсэлтэд тухай бүр нь хариулт өгч, зөвлөгөө өгсөн байна. Сургалтаар Хяналт, үнэлгээний үндэсний хорооны үйл ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналт шалгалтын байгууллагууллагуудын уялдаа холбоо, нэгдсэн байдлаар төлөвлөж, хяналт шалгалтыг зохион байгуулахад анхаарах асуудлаар улсын байцаагчдад мэдээлэл өглөө.	
4.	Олон Улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийн хүрээнд улсын байцаагчдын мэдлэг, ур чадварыг сайжруулах зорилгоор улсын байцаагчдыг мэргэшүүлэх сургалтыг танхимын болон онлайн хэлбэрээр зохион байгуулах	ОУХБ (ILO)-ын төсөв	Сургалтын тоо	2	-	2	Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдад зориулсан Албадан хөдөлмөр товч лавлах болон 07.1.1.а кодтой хяналтын хуудсаар шалгалт хийх практик удирдамжийн талаарх ойлголт өгөх танхим, цахим хосолсон сургалтыг ОУХБ, Бриж-2 төслийн багтай хамтран 2025.04.29-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад нийт 76 улсын байцаагч хамрагдав.	100
Нийт 3 зорилт 26 арга хэмжээ. Үүнээс: 100%-10, 90%-12, 70%-2, 50%-1, Хугацаа болоогүй-1.								91.0

Төлөвлөгөөг үнэлсэн:
Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)


Тэмдэг

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:
Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
(албан тушаал)


(гарын үсэг)

Төсвийн шууд захирагч
/Л.Мөнхзул/

(огноо)



(гарын үсэг)

Нэгжийн дарга
/Д.Ренчиндорж/

(огноо)

Тайлагнасан:
Салбарын хяналтын газрын дарга

(албан тушаал)


.....
(гарын үсэг)

.....
Нэгжийн дарга

/Б.Батзориг/

(огноо)

САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТЗОРИГЫН 2025 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яам

Нэгжийн нэр: Салбарын хяналтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт (70 оноо)
1	2	3	4
1.	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт	91.0	64

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Арга хэмжээ 1. <i>Хиймэл дагуу ухаан ашиглах урлагтанд хамрагдсан бөгөөд AI-ыг өдөр тутмын ажилдаа хэрхэн ашиглах талаар бие даан судалж байлаа.</i>		12
2.	Арга хэмжээ 2. <i>ОУХБ болон бусад байгууллагаас зохиогдох байгаа сургалт, зөвлөгөөнд хамрагдаж албаран хөдөлмөр, хүүргийн хөдөлмөр эрхлэн, ГАБ болон бусад сувгаар хяналт шалгалтын шинэ шаардлагатай мэдлэг, мэдлүүрийн мэтгэл авч байлаа.</i>		12
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо			12

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	13

2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	13
4.	Манлайлах	13
5.	Багаар ажиллах	13
6.	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	13
8.	Мэргэжлийн ур чадвар 2.	13
9.	Мэргэжлийн ур чадвар 3.	13
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		13

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)	70 хүртэлх оноо 64.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 12
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Төсвийн шууд захирагчийн үнэлгээ)	15 хүртэлх оноо 13
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	 оноо
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		89.0

Үнэлгээ өгсөн:

Төрийн нарийн бичгийн дарга

(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

[Signature]

(гарын үсэг)

Д.МӨНХЗУЛ

(албан хаагчийн нэр)

..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:

Салбарын хяналтын газрын
дарга

(албан тушаал)

Нэгжийн дарга:

.....

(гарын үсэг)

/Б.БАТЗОРИГ/

(албан хаагчийн нэр)

..... (огноо)